

Б.Баярцэцэг БСШУСЯ-ны харьяа Боловсролын
Хүрээлэнгийн Дээд болон Мэргэжлийн боловсролын судалгааны секторын
эрхлэгч

Хураангуй

Монгол улсын оюутан залуусын хөгжлийг тэдний дээд боловсролын сургалтын байгууллагаар эзэмшиж байгаа мэдлэг, чадвартай нягт уядаг. Оюутан залуусын эзэмших мэдлэг, чадварыг глобальчлал, мэдээлэл технологийн хөгжлийн дэвшил, байгаль орчны тогтвортой байдлыг дэмжих бодлого тодорхойлж байна.

Монгол Улсын "Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал", "Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", "Ногоон хөгжлийн бодлого", "Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал", "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" зэрэг бодлогын баримт бичгүүдэд Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлж, насан туршийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, шинжлэх ухаан-үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлж байна.

Олон улсын хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдөхүйц мэдлэг, ур чадвартай төгсөгчдийг бэлтгэн гаргадаг дээд боловсролын тогтолцоотой болох, Технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг ДНБ-ний 3 хувь хүртэлх түвшинд хүргэх зорилт дэвшүүлээд байна.

"Боловсрол", "Шинжлэх ухаан, технологи", "Аж үйлдвэр", "Өндөр технологийн аж үйлдвэр", "Инноваци", "Хөдөлмөр эрхлэлт" зэрэг төрөөс баримтлах зарим салбарын бодлогод Боловсролын салбарт олон улсын стандартыг мөрдүүлж, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, хүний хөгжлийг дээшлүүлэхэд чиглүүлэх, Шинжлэх ухааны шинжилгээ, судалгаа, инновацийг стратегийн ач холбогдолтой салбаруудад төвлөрүүлж, эдийн засгийн бүтээмж, өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх, Өндөр технологийн хөгжлийг дэмжиж, нанотехнологи, биотехнологи, мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт олон улсын тавцанд өрсөлдөх чадавхийг хөгжүүлэх, Дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалж, иргэдээ ажлын байраар найдвартай хангах ... зорилтуудыг тусгасан байна.

"Боловсрол" үндэсний хөтөлбөр (2010-2021 он), Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.18-д " ... хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн

бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх ... ” – ээр заасан байна.

Оюутан залуусын мэдлэг, чадварыг тодорхойлох дээрх хүчин зүйлсийг бид дэлхийн, бүс нутгийн, үндэсний, салбарын, байгууллагын түвшинд дээд боловсролын хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн хэрэгжүүлэхэд тулгамдаж буй бэрхшээл, шийвдэрлэх арга замыг тодорхойлоход чуулганд оролцож байгаа салбарын эрдэмтэн судлаач, багш мэргэжилтэн, оюутан залуус Та бүхний анхаарлаа хандуулахыг хүсэж байна.

Түлхүүр үг: хөгжлийн бодлого, тогтвортой хөгжил, ногоон хөгжил, мэдээллийн технологи, 21-р зууны чадвар, оюутан

Тулгамдаж буй бэрхшээл

Бид хэнийг бэлтгэн гаргаж байна вэ?

Оюутан залуусдаа бидний эзэмшүүлж буй чадвар тэдний болон нийгмийн, цаашлаад дэлхийн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хэр хангаж байна вэ?

Бид оюутандаа мэдлэг, чадварыг хэрхэн эзэмшүүлж байна вэ?

Шийдвэрлэх арга зам

Үндэсний хэмжээнд “мэргэжилтэн” гэж хэн бэ гэдгээ тодорхойлох (загвар боловсруулах)

Их, дээд сургуулиуд төгсгөн гаргаж байгаа бүтээгдэхүүнээ нийтлэг болон онцлогоо (салбар сургуулийн онцлогоо тусгасан) тодорхойлох. Ингэхдээ үе шаттайгаар тухайлбал, I түвшний оюутан хэн байх вэ ? II түвшиндээ III түвшиндээ IV түвшиндээ гэх мэт

Их, дээд сургуулиуд чадварын жагсаалтаа гаргах

Жагсаалтад байгаа чадваруудыг хэрхэн эзэмшүүлэх арга зүйгээ боловсруулах.

Ашигласан ном зүй

(2015). ОУВС. 2015. Монгол Улс: 2015 оны Дүрмийн IV заалтын дагуу хийгдсэн зөвлөлдөх хэлэлцүүлгийн тайлан. Улаанбаатар

(2015). НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр 2015. Хүний хөгжлийн тайлан 2015: Хүний хөгжлийн төлөөх үйл ажиллагаа. Нью-Йорк

(2016). Монгол Улсын УИХ. Монгол Улс.Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030. Улаанбаатар.

НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ерөнхий конвенц. Парисын гэрээ.

(2016). Дэлхийн эдийн засгийн форум. 2016. Глобал өрсөлдөх чадварын тайлан, 2016–2017. Женев хот. Үндэсний бүртгэл, статистикийн газар ба Дэлхийн банк. 2015. Ядуурлын нөхцөл байдал: Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2014. Улаанбаатар

(2016). Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжих мөрийн хөтөлбөр.
Улаанбаатар хот

АХБ 2014-2020 он хүртэлх стратегийн дунд хугацааны үнэлгээ

Хувьсан өөрчлөгдөж буй Ази, Номхон далайн сорилыг сөрөх нь. Манила хот

(2016).Шинжлэх ухаан технологийн их сургууль-2021. Мастер төлөвлөгөө.Улаанбаатар

<https://21centuryedtech.wikispaces.com/21+Century+Info>

The Popularity of Online Courses & E-Learning in 2016 Based On Trends & Statistics